

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
“СПОРТ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА”-НЫ 2023 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН
БОЛОН ОРОЛЦСОН ТАЙЛАН

2023 оны 11 дүгээр сарын 22

Улаанбаатар хот

Нэг. Спортын тэмцээн уралдаан

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/13 дугаар тушаалаар “Соёл, спорт хамтлаг”-ийн ажлын хэсэг байгуулагдаж, хийх ажлын төлөвлөгөө гарган, газрын даргаар 02 дугаар сарын 28-ны өдөр батлуулан ажиллав.

2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар нийт 7 удаа, давхардсан тоогоор 19 төрлийн тэмцээн, уралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 318 албан хаагч хамрагдав.

Төлөвлөгөөний хүрээнд газрын хэмжээнд 2 төрлийн тэмцээнийг зохион байгуулав.

1. Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, 2023 оны төлөвлөгөөний хүрээнд байгууллагын аварга шалгаруулах “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг удирдамж, хөтөлбөр боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр газрын даргаар батлуулан, “Соёл, спорт хамтлаг”-ийн ажлын хэсэг 03 дугаар сарын 11-ний өдөр Ус сувгийн удирдах газрын спорт зааланд зохион байгуулж, нийт 76 албан хаагч оролцов.




2. 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр газрын даргаар батлуулсан удирдамж, хөтөлбөрийн дагуу “Гар бөмбөг-ийн” аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Ерөнхий боловсролын 48 дугаар сургуулийн спорт зааланд зохион байгуулж, 7 багийн нийт 69 тамирчид оролцов.



Бусад цаг үеийн олон нийтийг хамарсан (Цасны баяр, Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит 5 төрөлт тэмцээн, Эрүүл мэндийн цахим гүйлт 2023, Улаанбаатар марафон 2023, Нийслэлийн Засаг даргын нэрэмжит тэмцээн) ажлыг тухай бүр төлөвлөгөө, хөтөлбөр гарган батлуулан ажиллав.

1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн 3/38 тоот албан бичгийн хүрээнд газрын албан хаагчдыг “Цасны баяр” өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулахаар төлөвлөгөө гарган, хөтөлбөр боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр газрын даргаар батлуулсан. 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн газрын даргын А/12 дугаар тушаалын хүрээнд “Цасны баяр”-ын арга хэмжээг зохион байгуулав. 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Хандгайтын “Янзага” зуслангийн цанын баазад зохион байгуулагдсан арга хэмжээнд нийт 65 албан хаагч хамрагдав. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан бүжгийн тэмцээнд Э.Одчимэг, А.Тамир нар амжилттай оролцож 5 дугаар байр эзлэв.

Газрын албан хаагчдын дунд 3 төрлийн тэмцээн (цасны сумо, цасны бүжиг, морин барилдаан) зохион байгуулж, түрүүлсэн албан хаагчдыг мөнгөн шагналаар шагнав. Хэлтэс бүр эко хоол бэлтгэн цэвэр, эрүүл агаарт хооллов. Хоолны зураг, тэмцээн зохион байгуулсан дүрс бичлэгийн Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Ахлах мэргэжилтэнд viber-аар илгээв. Нийслэлийн хэмжээнд нийлбэр дүнгээр 4 дүгээр байр эзлэв.



2. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/666 тоот албан бичгийн хүрээнд Ерөнхий менежерийн нэрэмжит спортын 5 төрөлт (сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, ширээний теннис, шатар) тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 37 албан хаагч төрөл тус бүрд амжилттай оролцов.



3. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн 2/118 тоот албан бичгийн хүрээнд албан хаагчдыг “Эрүүл мэндийн цахим гүйлт 2023”-д оролцуулахаар газрын дотоод сүлжээгээр мэдээлэл хүргэн ажиллав. “Эрүүл мэндийн цахим гүйлт 2023” арга хэмжээ 2023 оны 05 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 6 хэлтсийн 9 албан хаагч, нийт 139.4 км зам гүйж амжилттай оролцов. Үүнд:

1. Хууль, дотоод хяналтын хэлтэс 1 албан хаагч – 3.47 км
2. Төлөвлөлт судалгааны хэлтэс 1 албан хаагч – 3.81 км
3. Мэдээллийн технологийн хэлтэс 1 албан хаагч – 7.3 км
4. Барилга захиалагчийн хэлтсийн 3 албан хаагч -18.19 км
5. Захиргааны хэлтэс 1 албан хаагч – 32 км
6. Санхүү, аж ахуйн хэлтэс 2 албан хаагч – 74.63 км

4. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/327 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 3/138 тоот хамтран ажиллах тухай ирүүлсэн албан бичиг, удирдамжийн хүрээнд “Улаанбаатар марафон-2023” гүйлтийн талаарх мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан, ажилтнуудад мэдээлэл хүргэсэн. 5 км-ийн зайд гүйх 9, 10 км-ийн зайд гүйх 1 албан хаагчийн мэдээллийг <http://ubmarathon.hiray.mn/> хаягаар онлайнаар бүртгэлжүүлэн, төлбөрийг hiray апплейкешнаар хийж баталгаажуулав. “Улаанбаатар марафон-2023” Олон улсын гүйлт 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж, нийт 10 албан хаагч амжилттай оролцов.



5. Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 3/200 тоот, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 01/1864 тоот албан бичгүүдийн хүрээнд бүсийн аварга шалгаруулах спортын 4 төрөлт (сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, ажлын байрны дасгал) тэмцээн 2023 оны 10 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж давхардсан тоогоор 52 газрын албан хаагчид амжилттай оролцов.

1. “Ажлын байрны дасгал”-ын төрөлд 5 дугаар байр



1. “Гар бөмбөг” эрэгтэй баг тамирчид 3 дугаар байр, хүрэл медаль



2. “Сагсан бөмбөг”-ийн эрэгтэй баг тамирчид 2 дугаар байр, мөнгөн медаль



3. “Сагсан бөмбөг”-ийн эмэгтэй баг тамирчид 1 дүгээр байр, алтан медаль-Шигшээ тэмцээнд оролцох эрх



4. “Сагсан бөмбөг”-ийн эмэгтэй шилдэг тоглогчоор Б.Мөнхбаясгалан тус тус шалгарав.



Газрын баг тамирчид багийн нийлбэр дүнгээр 2 дугаар байр эзэлж, 2024 онд бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах “Шилжин явах цом”-ыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-аас хүлээн авав.



2023 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Сагсан бөмбөг”-ийн шигшээ тэмцээнд газрын эмэгтэй баг тамирчид амжилттай оролцов.

Хоёр. Олон нийтийн арга хэмжээ:

Нийслэл, газар, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 10 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 474 албан хаагч оролцов.

1. “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын үе үеийн удирдлага, ахмадууд, нийт ажилтнуудын уулзалт” 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж, нийт 156 албан хаагч оролцов.



3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/66 тоот албан бичгийн дагуу “Их цэвэрлэгээ 90 минут” цэвэрлэгээ 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж, 40 албан хаагч оролцов.



4. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/66 тоот албан бичгийн хүрээнд “Хоггүй шинэлье их цэвэрлэгээг” 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулж, 23 ажилтан оролцов.



5. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/66 тоот албан бичгийн хүрээнд “Хотоо цэвэрлье” бүх нийтийн

хаврын их цэвэрлэгээг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж, 75 албан хаагч оролцов.




6. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Ногоон хот иргэний оролцоо” хаврын мод тарих арга хэмжээний хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Чингэлтэй дүүргийн 19-р хороо Дээд салхитын аманд нийт 30 ширхэг шинэс модыг 26 албан хаагчид тарив.



7. Эх дэлхийн өдрийг тохиолдуулан Экологийн цагдаагийн албанаас “Хүн бүр байгаль хамгаалагч” нөлөөллийн аян 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Монголын хүүхдийн ордны талбайд зохион байгуулагдаж, 30 албан хаагч оролцов.



8. 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан “Зүүн Азийн Залуучуудын наадам”-ын нээлтийн арга хэмжээнд оролцохоор нийт ажилтнуудаас санал авч бүртгэл гарган, НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Л.Ариунзаяад уламжлан 65 тасалбар хүлээн авсан ба албан хаагчдад мэдээлэл хүргэн бүрэн хамруулав.



9. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01/2177 тоот албан бичгийн хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил хашаа, талбайд хуримтлагдсан хог хаягдлыг ачиж, тээвэрлэх, зорилгоор 29 албан хаагч оролцож, Монголын хөрөнгийн биржийн баруун урд тал, Бодь цамхагийн явган хүний зам, СУ худалдааны төвийн арын явган хүний зам дагуух, булан тохойн ил задгай хог хаягдал болон тамхины ишийг цэвэрлэв.



10. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр ирүүлсэн 01/2177 тоот албан бичиг, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний замын цас цэвэрлэх, цэвэрлэгээний ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “Да хүрээ”-захаас “Шар хадны эцэс” хүртэлх нийтийн эзэмшлийн талбай явган хүний замын зорчих хэсгийн цасыг нийт 26 албан хаагч цэвэрлэв.



2023 оны 11 сарын 21-ний өдрийн байдлаар нийт 17 удаагийн тэмцээн уралдаан, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 792 албан хаагч хамрагдав.